



**МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 06 өдөр


Дугаар 127

Номгон

**Монголын хүүхдийн спортын VII наадмын
бэлгэдэл, брэнд бүүк гаргах ажлыг зохион
байгуулах тухай**

Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны Монголын хүүхдийн спортын зуны VII наадмыг 2023 онд зохион байгуулах тухай А/209 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Спортын наадам хойшлуулах тухай" 268 дугаар тогтоол, 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын 2.1, 3.11, 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай 12/54 дугаар тогтоолын хавсралтын 1.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1. Монголын хүүхдийн спортын VII наадмын бэлгэдэл, брэндбүүк гаргах ажлыг зохион байгуулсугай.
- 3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 5.000.000 (Таван сая) төгрөгийг Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.
- 4. Монголын хүүхдийн спортын VII наадмын бэлгэдэл, брэндбүүк гаргах ажлыг чанартай зохион байгуулж, тайлагнахыг Биеийн тамир, спортын газар (Б.Оюунбаатар), Нийгмийн бодлогын хэлтэс (Наранбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.
- 5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН